

АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. Бүтэц, зохион байгуулалт, хүний нөөц

1. Бүтэц зохион байгуулалт
2. Хүний нөөц

ХОЁРДУГААР БҮЛЭГ. Газрын харилцааны чиглэлээр

3. Геодези, зураг зүй
4. Инженер хайгуул, мониторинг
5. Газар зохион байгуулалтын төлөвлөлт, газар өмчлөл
6. Газрын кадастр
7. Газрын төлбөр, татвар
8. Мэдээллийн технологи

ГУРАВДУГААР БҮЛЭГ. Барилга, хот байгуулалтын чиглэлээр

1. Хот байгуулалт
2. Барилга захиалагчийн хяналт
3. Барилгын материал, лаборатори
4. Орон сууц, нийтийн аж ахуй

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. Төсөв санхүү

ТАВДУГААР БҮЛЭГ. Сургалт сурталчилгаа, ил тод байдал


1.1 БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Дундговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь Монгол улсын Үндсэн хууль, Газрын тухай хууль, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Барилгын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомж, журмыг мөрдлөг болгон Дундговь аймгийн газрын нөөцийг төлөвлөх, зурагжуулах, иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид газар эзэмшүүлэх, ашиглуулах, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулах, энэ талаар аймаг, сумын Засаг даргын шийдвэр гаргах түвшинд мэргэжлийн туслалцаа үзүүлэх замаар газрыг зөв зохистой ашиглах, хамгаалах, газрын эдийн засгийн үр өгөөжийг иргэд, байгууллага, аж ахуй нэгж хүртэх нөхцлийг бүрдүүлэх, Орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн төлөв, хэрэгжүүлэх үе шатны зорилттой уялдуулан барилга, дэд бүтэц, барилга угсралт, их засварын ажилд захиалагчийн хяналт тавих, хот байгуулалт, хот суурины ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн төлөвлөгөө, барилга байгууламжийн зураг төсөл, тэдгээртэй холбогдолтой судалгаа хийж, санал гаргах, мэргэжлийн зөвлөгөөгөөр хангах, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Дундговь аймгийн Газрын алба нь аймгийн Засаг даргын 2003 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн 22 дугаар захирамжаар байгуулагдсан. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 67 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн Засаг даргын 2009 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 35-р захирамжаар Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар болон ажиллаж байна.

Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2015 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн Б/65 дугаар тушаалаар 17 орон тоотойгоор батлагдсан ба 2017 онд батлагдсан цалингийн сангийн дагуу 14 албан хаагч ажиллаж байна.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргатай байгуулсан 2016 оны үр дүнгийн гэрээг сайн үнэлгээтэй, аймгийн Засаг даргатай байгуусан 2016 оны үр дүнгийн гэрээг маш сайн үнэлгээтэй дүгнүүлж, 2017 оны 1 дүгээр улиралд удирдлагуудтай үр дүнгийн гэрээг байгуулсан.






1.2 ХҮНИЙ НӨӨЦ

Тус байгууллага нь хүний нөөцийг хөгжүүлэх, төрийн албан хаагчдыг сургаж, бэлтгэх, шилж сонгох, ажилд нь дадлагажуулж мэргэшүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах, хүний нөөцийн удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох зорилгоор хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулж, хөтөлбөрт тусгасны дагуу жил бүр албан хаагчдынхаа сургалтын хэрэгцээг тодорхойлж сургалтын төлөвлөгөө боловсруулан батлуулж төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.


Нийт 14 албан хаагчдаас төрийн захиргааны албан хаагч 11, төрийн үйлчилгээний албан хаагч 1 байгаа бөгөөд эдгээрийн 8 нь буюу нийт албан хаагчдын 57 хувь нь төрийн захиргааны зэрэг дэвтэй албан хаагчид байна.

Боловсролын байдлаар нь авч үзвэл нийт албан хаагчдын 13 албан хаагч буюу 93 хувь нь дээд боловсролтой, 1 албан хаагч тусгай дунд боловсролтой бөгөөд тэдгээрийн 2 албан хаагч буюу 16 хувь нь магистрын, 11 албан хаагч нь бакалаврын зэрэгтэй албан хаагчид ажиллаж байгаа ба томилгооны зөрчилтэй албан хаагч байхгүй болно. Нийт албан хаагчдын 35 хувь нь буюу 4 нь салбарын мэргэшсэн инженер, мэргэшсэн жолооч 1 ажиллаж байна.

Байгууллагын албан хаагчдын 4 нь буюу 28 хувь нь эмэгтэй, 10 нь буюу 72 хувь нь эрэгтэй албан хаагч байна.



Насны ангилалаар нь авч үзвэл 79 хувийг 35 хүртэл насны залуучууд, 14 хувийг 36-50 настай буюу дунд насны хүмүүс, 6 хувийг 51-60 настай буюу ахимаг насны хүмүүс эзэлж байна.




Албан хаагчдын 6 нь буюу 43% нь 1-5 жил, 7 нь 6-15 жил /нийт албан хаагчдын 50 хувь/, 7% нь 21-ээс дээш жил төрийн албанд ажиллаж байна.






ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛЭЭР



2.1 ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙ

2.1.1 ГЕОДЕЗИЙН БАЙНГЫН ЦЭГ ТЭМДЭГТ

2017 онд: Аймгийн хэмжээнд 2016 оны жилийн эцсийн байдлаар 432 геодезийн байнгын цэг тэмдэгт байхаас 430 цэг тоологдсон ба Дэлгэрцогт, Дэрэн сумдад устсан цэг 2 байсан. Тайлант онд Сайнцагаан суманд “Модерн маркет” ХХК-ийн хүсэлтээр шинээр байгуулсан GPS-ийн зураглалын сүлжээний геодезийн цэгүүдийн хэмжилтийн болон улсын нэгдсэн сүлжээнд холбосон талаарх тайланг “Эм Си Ай Ар Эн” ХХК-аас хүлээн авсан. ПЦ104-ПЦ109 хооронд нийт 6 цэг шинээр байгуулагдсан. Геодезийн байнгын цэг, тэмдэгт байрлаж байгаа газарт зам болон барилга байгууламж барих, газар шорооны ажил хийх тухай хүсэлт ирээгүй байна. Сумдад геодезийн байнгын цэг тэмдэгтийг хамгаалах, тооллогыг зохион байгуулах тухай албан бичгийг тус газрын 2017 оны 05 сарын 26-ны өдрийн 1/158 дугаар албан тоотоор хүргүүлж аймгийн хэмжээний тооллогын нэгдсэн дүнг хугацаанд нь хүргүүлэхээр ажиллаж байна. Мөн тус аймгийн өндрийн II ангийн сүлжээг шинэчлэх, сүлжээний давтан хэмжилтийг “Геосет” ХХК хийж гүйцэтгэж байгаа. Манай аймгийн хувьд шинээр байгуулсан цэг байхгүй 14 цэгийн тодруулалтын 12 цагийн статик хэмжилт хийгдсэн.




Зураг 2.1.1. Дундговь аймгийн геодезийн байнгын цэг тэмдэгтийн мэдээллийн сан

2018 онд төлөвлөж буй ажил: Өндрийн II ангийн сүлжээг шинэчлэх, сүлжээний нивелирдлэгийн ажил, цэг тэмдэгтийн аймгийн нэгдсэн тооллого зохион байгуулах мэдээллийн санг шинэчлэх

2.1.2 ХАЯГЖУУЛАЛТ

2017 онд: Хаягийн мэдээллийн сангийн зургийг ГЗБГЗЗГ-аас 2017 оны 03 сарын 17-ны өдөр хүлээн авч сумдын 1:1000, 1:100000-ны масштабтай зургуудыг тулган шалгах, зөрүүтэй мэдээг ирүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэх тухай албан бичгийг сумдад хүргүүлж ирүүлсэн саналыг нэгтгэн тус газрын 2017 оны 1/156 тоот албан бичгээр ГЗБГЗЗГ-т хүргүүлэн ажилласан бөгөөд хаягийн мэдээллийн сангийн зургийн дагуу сум суурин газар, зам дагуух тэмдэглэгээг суурилуулах ажил болон мэдээллийн санг тогтмол хөтлөн явуулах, сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж буй газруудад журмын дагуу хаягийн зураг зохиож нэр, дугаар өгч ажиллахыг сумдын засаг дарга нар, орлогч дарга нарын сургалт, газрын даамлуудын ээлжит сургалтын үеэр танилцуулга, мэдээлэл, чиглэл өгч ажилласан ба “Гудамж, зам талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам”-ыг үндэслэн аймгийн хэмжээнд нийт гудамж, зам талбай, 28 барилга, 1489 нэгж талбарт нэр, дугаар, хаяг өгч мэдээллийн сангийн дагуу хаяг олгох үйл ажиллагааг зохион байгуулсан.

Дэлгэрцогт сум 2017 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөнөөс 1,8 сая төгрөгийг төсөвлөж тэмдэгжүүлэх ажлыг эхлээд байна.



Зураг 2.1.2. Дэлгэрцогт сумын хаягийн тэмдгийн суурилуулах ажил


2018 онд төлөвлөж буй ажил: Адаацаг, Баянжаргалан, Говь-Угтаал, Гурвансайхан, Өндөршил, Дэрэн, Эрдэнэдалай, Хулд, Луус, Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Сайнцагаан, Цагаандэлгэр сумдын төвд хаягийн тэмдэг суурилуулах ажилд нийт 127,200,000 төгрөгийг 2018 оны орон нутгийн хөгжлийн санд батлуулсан байна.

2.1.3 ТОМ МАСШТАБЫН БАЙР ЗҮЙН ЗУРГИЙН ШИНЭЧЛЭЛТ, ТОДРУУЛАЛТ

Улсын хэмжээнд зохион байгуулагдсан **“Монгол Улсын аймаг, сумын төвийн 1:1000-ны масштабтай байр зүйн зургийн тодруулалт, шинэчлэлийг хийх”** ажлын хүрээнд хийгдсэн аймаг, сумын төв, томоохон суурингийн 1:1000-ны масштабтай байр зүйн тоон зургийн мэдээллийн санг ГЗБГЗЗГ-аас 2017 оны 10 сарын 12-ны өдөр актаар хүлээн авч сумдад хүргүүлж хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлийг өгч ажиллалаа. Төсөл гүйцэтгэх үеэс хойшхи аймгийн төв болон сумын төвүүдийн 1:1000-ны масштабтай байр зүйн зургийг өөрчлөлт орох тухай бүрт нь баяжуулан ажиллаж ирсэн бөгөөд тайлант онд шинээр ашиглалтад орж буй нийтийн болон хувийн орон сууц, үйлчилгээний зориулалттай 14 барилга, “Тэс петролиум” ХХК-ийн ШТС 2, “Содмонгол” ХХК-ийн ШТС 1, “Дашваанжил” ХХК-ийн АХЦС, Өлзийт сумын инженерийн шугам сүлжээ, авто замын шинэчлэлийн ажил, Сайхан-Овоо сумын 200 хүүхдийн дотуур байрны барилга гэх мэт томоохон ажлуудын гүйцэтгэлийн схем байр зүйн зураглалын ажлуудад хяналтын хэмжилт хийн мэдээллийн санд хүлээн авч жижүүрийн хөтлөлтийг хийн тухайн агшны мэдээллээр мэдээллийн санг баяжуулан ажиллалаа. Газар эзэмших, өмчлөх эрх үүссэн 249 иргэн, ААН, байгууллагын захиалгын дагуу 321 нэгж талбарын эргэлтийн цэгийг газарт бэхлэх хүсэлтийг авч 258 нэгж талбарын эргэлтийн цэгийг газарт бэхлэн актаар хүлээлгэн өгсөн байна.



Сайхан-Овоо суманд тодруулалтын хэмжилт




Мэдээллийн сангийн баяжилт

Зураг 2.1.3. Хэмжилт, тодруулалт, мэдээллийн сангийн баяжилт

“Газар хөдлөлийн гамшгийн эрсдлийг бууруулах ажлын хүрээнд инженерийн барилга, байгууламж, шугам, сүлжээний мэдээллийн сан байгуулах” ажлын үр дүнг хэрэглээгээр шалган тодорхойлолтыг ГЗБГЗЗГ-т хүргүүлж газар дээрх болон доорх шугам сүлжээний мэдээллийн сангийн баяжилтыг бүртгэлжүүлж тайлант онд цэвэр усны шугам 1,99 км, дулааны шугам 0,91 км, холбооны шугам 1 км, ариутгах татуургын шугам 2,07 км, 2,01 км цахилгааны шугам, 1,5 км авто зам, гэрэлтүүлэг шинээр байгуулагдсаныг хэмжиж тодруулан мэдээллийн санг баяжуулсан байна. Зам, шугам сүлжээний хамгаалалтын зурваст газар давхцуулан олгохгүй байх, суурь мэдээллийн санг тухай бүр баяжуулан ажиллах зорилгоор “Дундговь-Ус” ОНӨҮГ, “Ган-Илч” ХХК болон бусад хангагч байгууллагын айл өрх, ААН, байгууллагыг цахилгаан, цэвэр ус, халаалтаар хангах, бохир усыг татан зайлуулах тухай техникийн нөхцөл олгох үйл ажиллагаанд хяналт тавин хамтран ажиллаж байна.

2.1.4 ГАЗАР ЗҮЙН НЭРИЙН МЭДЭЭЛЛИЙН САН, ТӨРИЙН НУУЦ

2017 онд: ГЗБГЗЗГ-ын ГЗЗХ-ээс 2017 оны 10 сарын 12-ны өдөр зохион байгуулсан сургалтаар мэдээллийн сан байгуулах арга зүйн зөвлөгөөг хангагдаж 1:100000 масштабтай байр зүйн зургийг үндэслэн тус аймгийн Сайнцагаан сумын газар нутгийн нэрийн зургийг тоон хэлбэрт загварын дагуу оруулж мэдээллийн сан байгуулагдсан. Цаашид бусад сумдын мэдээллийн санг байгуулах, 1:25000-ны масштабтай байр зүйн зургийн нэрийг тоон хэлбэрт оруулахаар төлөвлөн ажиллаж байна.




Зураг 2.1.4. Сайнцагаан сумын газар зүйн нэрийн мэдээллийн сан байгуулах ажил

2.2 ИНЖЕНЕР ХАЙГУУЛ, МОНИТОРИНГ

2.2.1 БЭЛЧЭЭРИЙН ГАЗРЫГ ФОТО МОНИТОРИНГИЙН АРГААР ҮНЭЛЭХ

Швейцарын хөгжлийн агентлагийн “Ногоон-Алт” төсөлтэй хамтран “Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх” сэдэвт сургалтад ГХБХБГ-ын мэргэжилтэн Б.Туул болон 15 сумын даамлууд нийт 16 мэргэжилтэн 2017 оны 08 сарын 09-11-ний өдрүүдэд хамрагдлаа. Уг сургалтаар бэлчээрийн ашиглалтын нөлөөллийг фото мониторингийн аргаар хяналт хийх ажлыг онол практик дээр хослуулан гүйцэтгэлээ.

2017 оны байдлаар Дундговь аймгийн хэмжээнд фото мониторингийн 114 байршилд ажиглалт, судалгаа хийж мэдээллийн сан үүсгэн бэлчээрийн төлөв байдал, чанарын өөрчлөлтийн явцыг жил бүрээр хянах, урьдчилан сэргийлэх, ашиглалтыг тохируулах, үнэлэлт дүгнэлт өгөх, зэргээр ажиллаж байна. Мониторингийн тайлан үр дүнг бэлчээрийн менежментийн хэвийн үйл ажиллагааг хянах, бэлчээрийн газар ашиглалтын үр нөлөөг үнэлэх, зэрэг суурь мэдээлэл болгон ашиглаж байна.




Зураг 2.2.1. Фото мониторингийн аргаар үнэлэх ажил

2.2.2 ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ ЧАНАРЫН УЛСЫН ХЯНАН БАТАЛГАА

Аймгийн төвийн сумын хянан баталгаа хийгдээгүй 121 аж ахуйн нэгж судалгааг гаргаж эхний ээлжинд зайлшгүй хянан баталгаа хийлгэх шаардлагатай ШТС болон халаалтын зуухнуудын газарт мэдэгдэл хүргүүлэн ажиллалаа.

2017 онд Гурвансайхан сумын нутагт орших “Жи пи эф” ХХК, “Билэгт хайрхан уул” ХХК, Дэлгэрхангай суманд байрлах “Макцемент” ХХК, Сайнцагаан сумын нутагт орших “Жаст Ойл” ХХК зэрэг аж ахуй нэгжийн захиалгат хянан баталгааны ажлыг ГЗБГЗЗГ-с улсын ерөнхий шинжээчээр баталгаажуулан ирүүлсэнийг актаар хүлээн авч архивт бүртгэн ажиллалаа. Мөн аймгийн хэмжээнд хянан баталгаа хийгдээгүй ААН-ийн судалгааг гарган шатахуун түгээх станц, халаалтын зуухнуудын газар эзэмшигч нарт газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийлгэх хугацаатай мэдэгдлийг 2017 оны 05 сарын 26-ны өдөр хүргүүлсэн. Үүний дагуу “Ариунболор” ХХК 4 байршилд, “Ган-Илч” ХХК 7 байршилд хянан баталгаа хийлгэх захиалга ирүүлснийг тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэх талаар зөвлөмжийг өглөө.



- Зураг 2.2.1. Газрын төлөв байдал чанарын хянан баталгааны тайлангууд

2017 оны 6 дугаар сарын 12-ны өдрөөс 6 дугаар сарын 16-ны өдрийн хооронд аймгийн хэмжээнд уул уурхайн ашиглалтын зориулалтаар ашиглагдаж байгаа “Тэм Тэл” ХХК, “Говьшоо” ХХК, “Аргатай” ХХК, “Монголросцветмет” ХХК, “Хөх дэл” ХХК, “Чин хаш” ХХК, “Мэжик бридж” ХХК зэрэг аж ахуйн нэгжүүдийн ашиглалт явуулж буй талбайд хяналт тавьж ажиллалаа. Тус газруудад Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 18 дугаар зүйлд зааснаар эдэлбэр газрын буюу тусгай зөвшөөрлөөр заагдсан талбайд үйл ажиллагаа явуулж буй эсэхэд магадлан хэмжилтийг хийх чиглэлтэй ажиллалаа.



Ажлын явцад дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- “Хөх дэл” ХХК, “Аргатай” ХХК зэрэг аж ахуйн нэгжүүд уурхайн эргэлтийн цэгийн шав тэмдэг байхгүй
- “Тэм тэл” ХХК-ийн эргэлтийн цэгийн шав тэмдгийг буруу тогтоосон

- Дээрх аж ахуйн нэгжүүдийн уурхай дээр байх бичиг баримтад эргэлтийн цэгийн шав тэмдэг тогтоосон тухай акт байхгүй

Дээрх илэрсэн зөрчлүүдэд дараах арга хэмжээг авлаа. Үүнд:



- Уурхайн ашиглалтын талбайн эргэлтийн цэгийн шав тэмдгийг тогтоолгох тухай албан мэдэгдэл, заавар зөвлөмж өгсөн
- Буруу тогтоогдсон эргэлтийн цэгийн шав тэмдгийг гүйцэтгэгч байгууллагаар дахин тогтоолгож актийг хүргүүлсэн
- Уурхай дээр байх бичиг баримтын бүрдлийг хангах, жил бүр ашиглалтын зориулалтаар эвдэгдсэн болон нөхөн сэргээсэн талбайн талаарх мэдээлэл болон зургийг холбогдох байгууллагад цаг тухайд нь хүргүүлж байх зөвлөмжийг өгч ажиллалаа.

Уул уурхайн зориулалтаар ашиглаж байгаа газрын Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийх газруудын судалгааг гаргаж Баянжаргалан сумаас “Тайшендевелопмент” ХХК, “Дуньли” ХХК, “Монголросцветмет” ХХК, Гурвансайхан сумаас “Монголын алт” ХХК (МАК), “Билэгт хайрхан уул” ХХК, “Эм Си Ти Ти” ХХК, “Жи пи эф” ХХК-ууд газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийлгэх судалгааг ирүүлсэн ба “Тотал Меп” ХХК, “Ашид-Ананда” ХХК, “Эко натур” ХХК зэрэг газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийх эрх бүхий мэргэжлийн байгууллагууд хийж гүйцэтгэн актаар хүлээн авч архивт бүртгэн ажиллаа. Мөн “Аргатай” ХХК, “Үнэн анд” ХХК, “Тайхар орд” ХХК, “Говьшоо” ХХК зэрэг аж ахуй нэгжүүд Газрын төлөв байдал чанарын хянан баталгаа хийлгэх хүсэлтээ ирүүлсэн бөгөөд эрх бүхий “Глобус” ХХК, “Цагаан уулын оргил” ХХК зэрэг компаниудтай холбон ажиллаж байна.

2.2.3 ОРОН НУТГИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗРЫН МЭДЭЭЛЛИЙН САН

Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээллийн санг шинэчлэх, шинээр орон нутгийн тусгай хамгаалалтанд авсан газруудын тоон мэдээллийг мэдээллийн санд нэгтгэж ажиллаж байна. 2017 онд аймгийн ИТХ-ын 2017 оны 04 сарын 25-ны өдрийн 19 дугаар тогтоолоор Сайнцагаан сумын “Суман хайрхан” ХХК, “Тогоогийн рашаа” ХХК-ний 49000 га, “Тэвшийн уул” ХХК-ний 686,4 га газрыг орон нутгийн тусгай хамгаалалтанд шинээр авсан ба тоон мэдээллийг мэдээллийн нэгдсэн санд бүртгэлжүүллээ.



Зураг 2.2.1. Орон нутгийн тусгай хамгаалалттай газрууд

2.3 ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ, ГАЗАР ӨМЧЛӨЛ

2.3.1 ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ТӨЛӨВЛӨЛТ



2017 онд: Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг 2006 онд “Цогтхангай” ХХК хийж гүйцэтгэн аймгийн ИТХ-ын 2007 оны 06-р сарын 15-ны өдрийн 03 дугаар тогтоолоор батлуулж хүлээлгэн өгсөн байдаг. ГХГЗЗГ-ын 2016 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 2/168 дугаар албан тоотоор ирүүлсэн дүгнэлтээр тус аймгийн ГЗБЕТ нь 2004, 2005 оны нийгэм, эдийн засгийн мэдээлэл дээр үндэслэн боловсруулсан өнөөгийн чиг хандлага, хөгжлийн төсөл хөтөлбөрүүд нийгэм эдийн засгийн нөхцөл байдалтай уялдахгүй байгаа тул хэрэгжүүлэх боломжгүй гэж дүгнэсэн. Дээрх дүгнэлтийг үндэслэн аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлыг аймгийн үндсэн чиглэлд тусгуулан 2017 оны 12 дугаар сарын 04-ний аймгийн ИТХ-аар 2018 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр аймгийн ГЗБЕТ-г шинэчлэн боловсруулахаар 150,0 сая төгрөгийг батлуулж ажиллалаа.

Тус аймгийн Говь-Угтаал сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний суурь мэдээлэл зургийн эмхэтгэлийг 2016 онд ГЗБГЗЗГ-аас хийж гүйцэтгэсэн. Уг мэдээлэл дээр үндэслэн 2017 онд “Вектор мэп” ХХК-тай гэрээ байгуулан уг төлөвлөгөөг боловсруулах ажил үе шаттайгаар зохион байгуулагдлаа.



Зураг 2.2.1. Говь-Угтаал сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулалт


Тус сумын газрын даамал, багийн дарга нар, сумын удирдлагуудтай хамтран хээрийн судалгааны ажлыг 2017 оны 04 сарын 07-11-ны өдрүүдэд хийж багийн ИНХ-аар хэлэлцүүлэн сумын иргэд, удирдлагуудаас гарсан саналыг төлөвлөгөөнд тусгуулан бэлэн болгож тус сумын ИТХ-аар хэлэлцүүлж 2017 оны 12 сарын 18-ний өдрийн 25 дугаар тогтоолоор сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг батлууллаа. Сумын 2018 оны тухайн жилийн ГЗБТ-г боловсруулахдаа орон нутагт зүй ёсны эрх баталгаажуулах ажлыг тусгах талаар сумын удирдлагууд болон газрын даамалд чиглэл өгч ажилласан.



2018 оны орон нутгийн төсөвт нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө хийлгэхээр Адаацаг, Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Хулд, Өлзийт, Цагаандэлгэр сумдад тус бүр 20 сая төгрөг тусгууллаа.


2.3.2 ГАЗАР ӨМЧЛӨЛ

Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль 2002 оны 06 дугаар сарын 27-ны өдөр батлагдаж 2003 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн. “Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай” хууль хэрэгжиж эхэлснээс хойш буюу 2003-2017 оны байдлаар Дундговь аймгийн хэмжээнд 12863 иргэнд 1092 га газрыг аймаг болон сумдын Засаг даргын захирамжаар гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар нэг удаа үнэгүй өмчлүүлсэн байна.



Зураг 2.2.1. Газар өмчилсөн байдал 2010-2017 он

Газар өмчилсөн иргэдийн тоог аймгийн нийт хүн амын тоонд харьцуулахад 28 хувьтай байна.



Зураг 2.2.1. Газар өмчлөлийн хувь /сумдаар/

Улсын Их Хурлаас 2008 оны 05 сарын 22-ны өдөр батлагдан гарсан “Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хууль хэрэгжиж эхэлснээс хойш өссөн дүнгээр 2697 насанд хүрээгүй иргэн газар өмчилж авч нийт насанд хүрээгүй иргэдийн 18 хувь нь өмчлөлийн газартай болоод байна.



Зураг 2.2.1. Насанд хүрээгүй иргэдийн газар өмчлөл

Монгол улсын иргэнд 2017 онд аймаг, сумын төвд өмчлүүлэх газрын зориулалт байршил, хэмжээг батлуулан иргэнд газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. 2017 онд 2955 иргэнд 250.46 га газрыг иргэнд өмчлүүлэхээр төлөвлөж нөөцийг тогтоосон. Үүнээс гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар одоо эзэмшиж байгаа хашааны газрыг өмчлүүлэхээр 7,85га газрыг иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр өмчлүүлэхээр 193.61 га газрыг, улсын чанартай зам дагуу 49 га газрыг өмчлүүлэхээр тус тус төлөвлөж батлуулсан. 2017 онд нийт 2737 иргэнд 229,32 га газрыг өмчлүүлээд байна. Үүнээс:

- Шинээр газар өмчилсөн 2044 иргэнд 180.24 га
- Одоо эзэмшиж байгаа хашаагаа өмчилсөн 26 иргэнд 2,39 га
- Улсын чанартай зам дагуу өмчилсөн 667 иргэнд 46.69 га газрыг тус тус өмчлүүлсэн бөгөөд хэрэгжилт 93 хувьтай байна.

д/д	Сумын нэрс	Өмчлүүлсэн газрын байршил	Иргэнд өмчлүүлсэн газрын нийт хэмжээ /га-гаар/	Өмчлүүлсэн газрын зориулалт / га-гаар /							газар өмчилсөн нийт иргэдийн тоо	Өмчлүүлсэн иргэдийн тоо								
				Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнэгүй өмчлүүлэх газрын нийт хэмжээ	Үүнээс			Аж ахуйн зориулалтаар өмчлүүлсэн газрын нийт хэмжээ	Үүнээс			Гэр бүлийн зориулалтаар үнэгүй газар өмчилсөн иргэдийн тоо	Үүнээс				Үүнээс			
					Одоо эзэмшиж байгаа газрын нийт хэмжээ	Шинээр өмчлүүлсэн газрын нийт хэмжээ	Улсын чанартай авто замын дагуу өмчлүүлсэн газрын нийт хэмжээ		Үр тарианы	Төмс, хүнсний ногооны			Газар тариалан-гийнхаас бусад	Одоо эзэмшиж байгаа газраа өмчлүүлэх	Шинээр газар өмчлөх	Улсын чанартай автозамын дагуу өмчлөх	Аж ахуйн зориулалтаар өмчлөх иргэдийн тоо	Үр тарианы	Төмс, хүнсний ногооны	Газар тариалангийнхаас бусад
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20
1	Дэлгэрцогт	Сумын төвд	0.31	0.31	0	0.31						3	3		3		0			
2	Дэрэн	Сумын төвд	2.83	2.83	0	2.83						40	40		40		0			
3	Говь-Угтаал	Сумын төвд	14.08	14.08	0	14.08						157	157		157		0			
4	Цагаандэлгэр	Сумын төвд	2.76	2.76	0	2.76						31	31		31		0			
5	Баянжаргалан	Сумын төвд	0.45	0.45	0	0.45						5	5		5		0			
6	Өндөршил	Сумын төвд	3.01	3.01	0.19							32	32	1	31		0			
7	Гурвансайхан	Сумын төвд	9.52	9.52	0	9.52						107	107		107		0			
8	Өлзийт	Сумын төвд	0	0	0	0						0	0		0		0			
9	Хулд	Сумын төвд	0.72	0.72	0	0.72						8	8		8		0			
10	Луус	Сумын төвд	3.4	3.4	0	3.4						36	36		36		0			
11	Дэлгэрхангай	Сумын төвд	0.58	0.58	0	0.58						5	5		5		0			
12	Сайхан-Овоо	Сумын төвд	4.28	4.28	0.14	4.14						48	48	2	46		0			
13	Эрдэнэдалай	Сумын төвд	10.2	10.2	0	10.2						137	137		137		0			
14	Сайнцагаан	Сумын төвд	172.23	172.23	2.06	123.48	46.69					2062	2062	23	1372	667	0			
15	Адаацаг	Сумын төвд	4.95	4.95	0	4.95						66	66		66		0			
Аймгийн хэмжээнд													2737	26	2044	667	0			

Зураг 2.2.1. 2017 оны газар өмчлөлийн төлөвлөгөө, гүйцэтгэл

2017 онд нийт газар өмчилж авсан иргэдийг сум сумаар харьцуулбал Сайнцагаан сум 2062 иргэн, Говь-Угтаал 157 иргэн, Эрдэнэдалай 137 иргэн, Гурвансайхан 107 иргэнд газар өмчлүүлж бусад сумаа тэргүүлсэн байна.

2.4 ГАЗРЫН КАДАСТР

2.4.1 “ЛЭНД МЕНЕЖЕР-2”

Газрын кадастрын мэдээллийн сангийн “Лэнд менежер” програм хангамжийг нэвтрүүлэх ажлыг аймгийн төвийн сум болох Сайнцагаан, Эрдэнэдалай сумдууд нэвтрүүлж, мэдээллийн санд иргэдээс ирсэн 1208 өргөдлийг бүртгэж газар өмчлөлийн 998 бүртгэл, газар эзэмшлийн 210 бүртгэл, 78 гэрээг шинэчлэн байгуулж мэдээллийн сангийн хэрэглэгчийн менежментийн төрлүүдэд бүртгэж, 958 кадастрын зургийг үнэт цаасан дээр хэвлэж иргэн аж ахуй нэгж байгууллагын хэрэгцээ шаардлагыг хангаж, өдөр тутмын үйл ажиллагаанд нэвтрүүлэн ажиллаж байна.

"Газрын кадастрын мэдээллийн сангийн “Лэнд менежер” програм хангамжийг нэвтрүүлэх, хөгжүүлэх“ сургалтыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, гэрээт ажлын гүйцэтгэгч "Топмаф" ХХК-тай хамтран 2017 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөс 11 дүгээр сарын 20-ны өдрүүдэд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 5 мэргэжилтэн, 15 сумын газрын даамлыг хамруулан амжилттай зохион байгуулж иж бүрэн компьютер, програм хангамжаар хангаж “Лэнд менежер” програм хангамж дээр ажиллах эрхийг баталгаажуулан, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2017 оны 11 дүгээр сарын 21 өдрийн А/271 дугаар тушаалын дагуу тус аймгийн Адаацаг, Эрдэнэдалай, Говь-Угтаал, Луус сумдын газрын даамлууд 2017 оны 11 дүгээр сарын 22-ний өдрөөс эхлэн "Лэнд менежер" програм хангамжийг өдөр тутмын үйл ажиллагаанд нэвтрүүлэн ажиллаж байна.



Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх" ажил болон Лэнд менежер програм хангамжийг нэвтрүүлэх ажлын хүрээнд иргэн, ААНБ-ын эзэмшил газар нь газар дээрээ зөрүүтэй байгаа 270 нэгж талбарын суурин судалгааг хийж ард иргэдэд мэдээллийг телевиз болон цахим хуудсаар мэдээллэж, зөрүүтэй байгаа эзэмшил газрын мэдээллийг ангилан, 231 иргэн, ААНБ-д зөвшөөрөлгүй эзэмшиж буй газраа

2.5 ГАЗРЫН ТӨЛБӨР, ТАТВАР, ҮНИЙН МЭДЭЭ


2.5.1 ГАЗРЫН ТӨЛБӨР

Газрын төлбөрийн ногдуулалтыг сум тус бүрээр гаргаж 180 сая төгрөг орон нутгийн орологод төвлөрүүлэхээр газрын төлбөрийн боломжит саналыг Аймгийн ИТХ-аар батлуулахаар хүргүүлсэн боловч 10 сая төгрөг нэмэгдэж 190 сая төгрөг болгон баталснаас 183,9 сая төгрөгийг орон нутгийн орологод төвлөрүүлж 96,7 хувийн гүйцэтгэлтэй ажиллалаа.

Газрын төлбөрийн орлогыг Адаацаг, Цагаандэлгэр, Баянжаргалан, Өлзийт, Луус, Эрдэнэдалай сумдууд 100,4-196,7 хувиар биелүүлж, нийт төвлөрүүлсэн газрын төлбөрийн 92,3 хувийг Сайнцагаан, Говь-Угтаал, Эрдэнэдалай, Баянжаргалан, Гурвансайхан, Өлзийт, Адаацаг сумдууд эзэлж байна.

Харин Говь-Угтаал, Гурвансайхан, Дэлгэрхангай, Сайнцагаан зэрэг сумдууд 8,3-22,8 хувиар, Дэлгэрцогт, Дэрэн, Өндөршил, Хулд, Сайхан-овоо сумдууд 35,4-68,4 хувиар төлөвлөгөөг тасалсан байна.

Сүүлийн 5 жилийн газрын төлбөрийн гүйцэтгэлийг графикаар харуулбал:



Газрын төлбөрийг төрлөөр нь авч үзвэл:

- Бэлчээрийн буюу малчин бус өрхөөс авсан газрын төлбөр 1,817,1 мян.төг 1.06 хувь
- ХАА-н барилга байгууламжийн дэвсгэр газар буюу өвөлжөө хаваржааны доорхи газрын төлбөр 6,864,0 мян.төг 3,58 хувь
- Барилга байгууламжийн дэвсгэр газрын газрын төлбөр 40,926,6 мян.төг 19,4 хувь
- ШТС-ын газрын төлбөр 1,254,5 мян.төг 0.5 хувь
- Гэр хорооллын иргэдээс авсан газрын төлбөр 136,1 мян.төг 0.1 хувь

- Уурхайн эдэлбэр газрын төлбөр 132,481,2 мян.төг 75 хувь
 - Жуулчны бааз, амралтын газруудын газрын төлбөр 455,0 мян.төг 0.25 хувь
- Нийт газрын төлбөрийн 72 хувийг уул уурхайн дэвсгэр газрын төлбөр эзэлж байна.

2.5.2 ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНИЙН МЭДЭЭ


Газрын биржийн цахим системд газар эзэмших эрхийн гэрчилгээ барьцаалсан 123 бүртгэлийг оруулж, Улсын тэмдэгтийн хураамжин тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.12 дахь заалтын дагуу орон нутгийн орлогод нийт 1,230,000 төгрөгийг төвлөрүүлж, 75 газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээг цахим биржид оруулж ажиллалаа.

Аймгийн хэмжээнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 74 газар худалдагдсан бөгөөд 1м² газрын дундаж үнэ 53,297 төгрөгөөр, худалдаа үйлчилгээний 1 газар худалдагдсан бөгөөд 1 м² газрын үнэ дунджаар 23,148 төгрөгөөр худалдагдсан байна.

Тус аймгийн газар, үл хөдлөх хөрөнгийн 2011 оны 33 үнийн мэдээ, 2012 оны 43 үнийн мэдээ, 2013 оны 119 үнийн мэдээ, 2014 оны 121 үнийн мэдээ, 2015 оны 68 зах зээлийн үнийн мэдээг газрын биржийн цахим програм хангамжид нөхөн бүртгэлээ.

2.6 МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

Байгууллагын цахим хуудас **dundgovi.gazar.gov.mn** болон орон нутгийн цахим хуудас **dundgovi.gov.mn**, байгууллагын facebook хуудсанд орон нутаг дахь салбарын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг тогтмол оруулан мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг ханган ажиллаж байна. 2017 он гарсаар дээрх цахим хуудаснуудад нийт 70 гаруй мэдээ мэдээллийг оруулж тогтмол баяжуулалт хийн ажилласан бөгөөд байгууллагын цахим хуудсанд нийт 800 гаруй иргэд хандалт хийж мэдээ мэдээллийг авсан байна.



“Газрын кадастрын мэдээллийн сангийн Лэнд менежер програм хангамжийг нэвтрүүлэх, хөгжүүлэх” гэрээт ажлын гүйцэтгэгч “Топмаф” ХХК-аас сумын газрын даамлууд ашиглах иж бүрэн компьютер, 3 үйлдэлт принтер, тог баригчийг хүлээлгэн өгсөн. Мөн тус аймгийн 15 сумын газрын даамлыг цахим хурлын системд холбох өөртэй микрофон агуулсан веб камер /Logitech C170/-ийг нийлүүлэгч “Би Си Ти” ХХК-аас худалдан авалтыг хийж гүйцэтгэсэн бөгөөд “Юнивишн” ХХК-аас газрын даамлуудын интернетийн үйлчилгээнд холбох гэр интернет төхөөрөмжийг хүлээн авч албан хэрэгцээнд ашиглахад бэлэн болоод байна.


Тус аймгийн төвийн сум /Сайнцагаан/-ын газрын даамлын компьютерыг байгууллагын нэгдсэн дотоод сүлжээнд шилэн кабель татан газрын даамлын өрөө болон ГХБХБГазрын серверийн RACK-д шилэн кабелийн төгсгөлийн төхөөрөмжийг байршуулан холбож нэгдсэн дотоод сүлжээнд холбож “Лэнд менежер” програм хангамжийг нэвтрүүлсэн.





3

**БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР**



3.1 ХОТ БАЙГУУЛАЛТ

3.1.1 МАНДАЛГОВЬ ХОТ

2017 онд: 2014 оны 08 сарын 18-ны өдөр “Эн Эй Пи групп” ХХК-тай улсын төсвийн 355 сая төгрөгөөр “Мандалговь хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах” гэрээ байгуулсан. Мандалговь хотыг 2015-2030 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2200 га газарт төлөвлөлт хийсэн бөгөөд 2015 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 1118/2015 дугаар магадлалын дүгнэлтээр баталгаажсан. Хот байгуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын дагуу аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2017 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 22 дугаар тогтоолоор батлуулсан. Мөн аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний **14** заалтыг батлуулсан.



Зураг 3.1.1. Мандалговь хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө

2018 онд төлөвлөж буй ажил: Мандалговь хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2017-2021 он хүртэл хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 5 тэргүүлэх чиглэл, 8 үндсэн зорилтын хүрээнд боловсруулах ажлыг дуусгаж, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулна.

3.1.2 СУМДЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2017 онд:

- Өлзийт сумын ерөнхий төлөвлөгөөг “Хот сервис” ХХК боловсруулан 2018 оны 01 дүгээр сарын 04-ны өдрийн 09/2018 дугаар магадлалын ерөнхий дүгнэлтээр батлуулсан.
- Гурвансайхан сумын ерөнхий төлөвлөгөөг “ББСМО” ХХК боловсруулж магадлалын ерөнхий дүгнэлтээр батлуулсан.

ХАРАГДАХ БАЙДАЛ



Улаанбаатар хот 2014 он

Дундговь аймгийн Өлзийт сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө

ХАРАГДАХ БАЙДАЛ

Зураг 3.1.2. Өлзийт сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө

2018 онд төлөвлөж буй ажил: Луус сум 29.4 сая төгрөг, Адаацаг 27.6 сая төгрөг, Баянжаргалан сум 29.23 сая төгрөг, нийт 86,23 сая төгрөгийг хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулахаар 2018 оны орон нутгийн хөгжлийн санд батлуулсан байна.

3.1.3 ГЭР ХОРООЛЛЫН ГАЗРЫГ ДАХИН ЗОХИОН БАЙГУУЛАХ

2017 онд: Нийгэм-эдийн засаг, тогтвортой хөгжлийг хангасан суурьшлын бүс болгон хөгжүүлэхэд гэр хорооллын газрыг дахин зохион байгуулж иргэдийн амьдрах орчин нөхцөл, хотын өнгө үзэмж, төлөвлөлтийг сайжруулах шаардлага тулгарч байна. Уг төлөвлөлтийг тус байгууллагын мэргэжилтнүүд боловсруулсан. 1-р зэрэглэлийн туслах авто замын хашлагын ирмэгээс өмчлөлийн газар хүртэл 11,5м гудамжны улаан шугам байхаар төлөвлөсөн бөгөөд авто замын өргөн 7м, ногоон байгууламжийн өргөн 3м, явган хүний замын өргөн 2м, 2-р зэрэглэлийн туслах авто замын өргөн 7м, нэг талаар 2м өргөн явган хүний замтай байхаар төлөвлөсөн.

Эхний ээлжийн блокийн төлөвлөлтөд хамрагдаж буй талбай 7.93 га байгаагаас 3.78 га нийтийн эдэлбэрийн газар, 55 нэгж талбарын 4,15 га өмчлөлийн газар хамрагдана.



аймгийн Засаг даргаар батлуулсан



Ерөнхий төлөвлөгөө



Одоогийн дэвсгэр зураг



Төлөвлөлт

Зураг 3.1.2. Сайнцагаан сумын 8-р багт хийх гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төсөл

2018 онд төлөвлөж буй ажил: Төлөвлөлтөнд хамрагдаж буй нэгж талбарын айл өрхийн иргэдийн саналыг авах төслийг эхлүүлэх боломж нөхцөлийг судлах

3.1.4 БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ЗУРАГ ТӨСӨЛ

2017 онд: 16 барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний зургийн даалгавар боловсруулж, 13 эх загвар зураг баталсан. Магадлалаар 13 барилга байгууламжийн зураг төслийг хянуулсан байна.

Аймгийн хэмжээнд мэдээллийн сангийн бүртгэлээр 1,99 км цэвэр усны шугам, 0,91 км дулааны шугам, 1 км холбооны шугам, 2,07 км ариутгах татуургын шугам, 2,01 км цахилгааны шугам, 14 барилга шинээр нэмэгдсэн байна. Мөн Өлзийт сумын 1,5 км авто зам, гэрэлтүүлэг, явган замын гүйцэтгэлийн зургийг мэдээллийн санд оруулсан байна.



1-р зэрэглэлийн гом замын дагуу 2 км авто замын гэрэлтүүлгийн ажлыг хүлээн авсан,
Байршил: Сайнцагаан сум, Санхүүжилт: Орон нутаг Өртөг: 176,4 сая төгрөг



1-р зэрэглэлийн гом замын дагуу 1,5 км урт явган хүний замын ажлыг эхлүүлсэн
Байршил. Сайнцагаан сум, Санхүүжилт: Орон нутаг Өртөг: 142,4 сая төгрөг



Өлзийт сумын 1,5км хатуу хучилттай авто зам, явган хүний зам, гэрэлтүүлэг
Санхүүжилт: Улсын төсөв, Өртөг 810,9 сая төгрөг



Олон нийтийн иргэний барилга
Байршил: Сайнцагаан сум, Санхүүжилт: хувийн хөрөнгө. Өртөг:

Зураг 3.1.3. 2017 онд гүйцэтгэсэн бүтээн байгуулалт ажлуудаас

2018 онд төлөвлөж буй ажил: Сайнцагаан суманд 1,5км явган хүний замын ажлыг дуусгах, Залуус хорооллын инженерийн шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж, дулааны станцын зэрэг томоохон төсөл хөтөлбөрийн хөрөнгийг шийдвэрлэх талаар арга хэмжээ авч ажиллана.

3.1.5 НОГООН БАЙГУУЛАМЖ

2017 онд: Сайнцагаан сумын “Мандал” ерөнхий боловсролын сургуулийн 2700м² эдэлбэр газарт зүлэгжүүлэлт, 2800 модны суулгацыг 5,7 сая төгрөгөөр, “Мандалговь-50” цэцэрлэг модот гудамж, авто замын дагуу 4 га талбайд 2500 модны суулгацыг 8 сая төгрөгийн хөрөнгөөр гүйцэтгэсэн байна.

Байгууллагын мэргэжилтнүүд Сайнцагаан сумын 7-р баг “Залуучууд”-ын гудамжны авто замын дагуу 1040м² талбайд ногоон байгууламжийн хайс хашааны ажлын зураг төсвийг боловсруулж 2018 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөд 46,5 сая төгрөгийг батлуулсан. Тус ажил нь Мандалговь хотыг 2015-2030 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөсөн.



Зураг 3.1.4. Сайнцагаан сум “Мандал сургуулийн ногоон байгууламж

2018 онд төлөвлөж буй ажил: Ногоон байгууламжийн хайсыг зургийн дагуу гүйцэтгүүлэх, мод бут тарих ажлыг зохион байгуулахад оролцох

3.2. БАРИЛГЫН ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТ

3.2.1 УЛСЫН ТӨСВӨӨР ХЭРЭГЖСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

2017 онд: Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн Сайхан-Овоо сумын 100 ортой дотуур байрны барилга угсралтын ажилд захиалагчийн хяналтыг 12 удаа, Өлзийт сумын 1.5км авто зам, явган хүний зам, гэрэлтүүлгийн ажилд захиалагчийн хяналтыг 7 удаа гүйцэтгэж ашиглалтад оруулсан. Дэлгэрхангай сумын 15 ортой эмнэлгийн барилгын угсралтын ажилд захиалагчийн хяналтыг 5 удаа гүйцэтгэж, хүйтний улирал эхэлсэнтэй холбогдуулан барилга угсралтын ажил түр зогссон. Мөн барилгын засварын ажил 10 хэрэгжиж ашиглалтад оруулсан байна. Барилга захиалагчийн хяналтыг тайланг бичиж архивлах ажлыг зохион байгуулсан.



100 ортой дотуур байрны барилга угсралтын ажлыг хүлээн авсан, Байршил: Сайхан-Овоо сум, Гүйцэтгэгч: "Эн ди констракшн" ХХК Өртөг: 1,371 тэрбум төгрөг



15 ортой эмнэлгийн барилга угсралтын ажлыг эхлүүлсэн, Байршил.: Дэлгэрхангай сум, Гүйцэтгэгч: "ОГОСЦ" ХХК Өртөг: 899,4 сая төгрөг



1,5км хатуу хучилттай авто зам, явган хүний зам, гэрэлтүүлэг. Байршил: Өлзийт сум Гүйцэтгэгч: "Санжам" ХХК, Өртөг 810,9 сая төгрөг



50 хүүхдийн цэцэрлэгийн дээврийн засвар Байршил: Цагаандэлгэр сум. Өртөг: 79 сая төгрөг.

Зураг 3.2.1. улсын төсвийн хөрөнгөөр 2017 онд хэрэгжсэн барилга, байгууламж, их засвар

2018 онд төлөвлөж буй ажил: Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл хөтөлбөрийг БНБД, зураг төслийн дагуу гүйцэтгүүлэх, тохирлын гэрчилгээтэй бүтээгдэхүүн, эдлэлийг хэрэглүүлэх талаар анхаарч ажиллана.

3.2.2 ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨР ХЭРЭГЖСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

2017 онд: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн аймгийн төвийн гэр хорооллын цахилгаан хангамжийг сайжруулах дэд өртөө барих ажил, цэнгэлдэх хүрээлэнгийн цэвэр усны холболт, гадна тохижилт, Хүүхдийн паркаас МТ шатахуун түгээх станц хүртэлх гэрэлтүүлэг, аймгийн МХГ-ын ажилчдын орон сууцны дэд бүтэц, Г.Чагдаржавын талбайн гэрэлтүүлэг тохижилт, Соёл амралтын хүрээлэнгийн тохижилт, Мандалговь хотын хуучин 9, 13-р байрны гадна фасадны засвар, аймгийн ЗДТГ-ын өрөө, танхим, буудлын засвар нийт 12 барилга угсралт, засвар, тохижилтын ажил захиалагчийн хяналт гүйцэтгэсэн байна.




Соёл амралтын хүрээлэнгийн тохижилт
Байршил: Сайнцагаан сум, Гүйцэтгэгч: " " ХХК
Өртөг: 65,5 сая төгрөг



Малчин хорооллын цахилгааны дэд өртөө
Байршил: Сайнцагаан сум, Гүйцэтгэгч: "Мон-Энержи" ХХК
Өртөг: 38,8 сая төгрөг



Мандалговь хотын хуучин 13-р байрны фасадны засвар. Байршил: Сайнцагаан сум
Гүйцэтгэгч: "Дархан-Үйлс" ХХК, Өртөг 76 сая төгрөг



Г.Чагдаржавын талбайн гэрэлтүүлэг тохижилт. Байршил: Сайнцагаан сум
Гүйцэтгэгч: "Тааны амт" ХХК, Өртөг: 27,1 сая төгрөг

Зураг 3.2.2. Орон нутгийн хөрөнгөөр 2017 онд хэрэгжсэн барилга, байгууламж, их засвар

2018 онд төлөвлөж буй ажил: Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл хөтөлбөрийг БНБД, зураг төслийн дагуу гүйцэтгүүлэх, тохирлын гэрчилгээтэй бүтээгдэхүүн хэрэглүүлэх талаар анхаарч ажиллана.

3.2.3 ХУВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БАРИГДСАН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ

2017 онд: Иргэн Б.Отгонбаатарын 16 айлын орон сууцны барилга, “Үлэмж инвест” ХХК-ний 12 айлын орон сууцны барилга, иргэн Д.Түвшиндэлгэрийн 12 айлын орон сууцны барилга, иргэн Ц.Ганцэцэгийн 2 давхар үлчилгээтэй орон сууцны барилга, “Эожин” ХХК-ний 2 давхар үйлчилгээний төвийн барилга, “Дашваанжил” ХХК-ний авто машин хийгээр цэнэглэх станцын барилга, “Сод Монгол групп” ХХК-ний ШТС-ын барилга угсралтын ажлуудад захиалагчийн хяналтыг гүйцэтгэсэн байна.



16 айлын орон сууцны барилга. Байршил: Сайнцагаан сум 7-р баг, Өртөг: 600 сая төгрөг



“Дашваанжил” ХХК-ний АХЦС-ын барилга
Байршил: Сайнуагаан сум, Өртөг: 427 сая төгрөг



“Эожин” ХХК-ний үйлчилгээний барилга
Байршил: Сайнцагаан сум,



12 айлын орон сууц Байршил: Сайнцагаан сум 7-р баг

Зураг 3.2.3. Хувийн хөрөнгө оруулалтаар 2017 онд хэрэгжсэн барилга, байгууламж

2018 онд төлөвлөж буй ажил: Хувийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих барилга угсралтын ажлыг БНБД, зураг төслийн дагуу гүйцэтгүүлэх, тохирлын гэрчилгээтэй бүтээгдэхүүн хэрэглүүлэх талаар анхаарч ажиллана.

3.3. БАРИЛГЫН МАТЕРИАЛ, ЛАБОРАТОРИ

3.3.1 БАРИЛГЫН МАТЕРИАЛ



2017 онд: Аймгийн Засаг даргын 2017 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А/216 дугаар захирамжаар “Барилгын материал үйлдвэрлэгч аж ахуй нэгжийг тохирлын гэрчилгээтэй болох, барилга угсралтын ажилд тохирлын гэрчилгээтэй материал, түүхий эдийг хэрэглүүлэх” шийдвэр гаргуулсан байна. Тус захирамжийн хэрэгжилтийг хангах чилэлээр дараах ажлыг зохион байгуулсан байна. Үүнд:

- 2017 оны 06 дугаар сарын 28-ны өдөр аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ, БХТ-ийн “Бүтээгдэхүүн баталгаажуулалтын алба”, аймгийн МХГ, ГХБХБГ, Стандартчилал, хэмжил зүйн хэлтэс хамтран “Барилгын чанар-аюулгүй байдал” сэдвээр сургалт зохион зохион байгуулж 12 аж ахуй нэгжийн 35 хүнийг хамруулсан байна.
- Барилгын материал үйлдвэрлэгч 2 аж ахуй нэгжийн бүтээгдэхүүнийг тохирлын баталгаажуулалтанд хамруулсан.
- Аймгийн хэмжээнд ашиглалтад орсон 14 барилга байгууламж дээр тохирлын гэрчилгээтэй бараа, материалыг хэрэглүүлсэн байна.

2018 онд төлөвлөж буй ажил: Барилга, байгууламжийн угсралтын ажлын явцад хөрөнгийн эх үүсвэр харгалзахгүйгээр тохирлын гэрчилгээтэй материал, эдлэл хэрэглүүлэх, барилгын материалын үйлдвэрлэлийг тохирлын гэрчилгээтэй болгож ажиллана.

3.3.2. БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ЛАБОРАТОРИ

2017 онд: Орон нутагт баригдаж буй барилга, байгууламжийн лабораторийн хяналтыг гүйцэтгэх зорилгоор “Барилгын материалын сорил шинжилгээний лаборатори”-ийн барилгын ажлын зураг төслийг “Проексисти” ХХК боловсруулж 2018 оны улсын төсвийн төсөл арга хэмжээний саналд тусгуулахаар арга хэмжээ авч ажилласан. Барилгын материалын сорил шинжилгээ явуулахад шаардлагатай 42 төрлийн стандарт, норм дүрмийн эмхтгэл худалдан авсан. Лабораторийн туршилт, судалгаанд шаардлагатай 44 нэр төрлийн 54.6 сая төгрөгийн өртөг бүхий бетон дүүргэгчийн, цементийн лабораторийн тоног төхөөрөмжийн хөрөнгийг 2018 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөд тусгаж шийдвэрүүлсэн байна. Мөн “Барилгын материалын лабораторийн дүрмийг боловсруулж аймгийн Засаг даргын 2017 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн А/418 дугаар захирамжаар батлуулсан байна.

Дундговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2017 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн ээлжит 6 дугаар хуралдааны ... дугаар тогтоолын ... дугаар хавсралт

Дундговь аймгийн 2018 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалт

№	Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний нэр хүчин чадал, байршил	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	2018 онд санхүүжилт
Нийт дүн				1,362,697,500	1,362,697,500
1. Хөрөнгө оруулалт				654,658,818	654,658,818
1.1. Шилжих хөрөнгө оруулалт				105,465,000	105,465,000
1.1.1	Цэнгэлдэх хүрээлэнгийн барилгын гадна цахилгааны ажил	2017	2018	50,000,000	50,000,000
1.1.2	Зүүн бүсийн сум дундын Эрүүл мэндийн төвийн ажилчдын сууц	2017	2018	55,465,000	55,465,000
1.2 Шинэ хөрөнгө оруулалт				549,193,818	549,193,818
1.2.1	Буйнт гүүрнээс МТ шатаахуйн түгээх станц хүртэл гадна гэрэлтүүлэг	2018	2018	60,693,818	60,693,818
1.2.2	Өвлийн нарлаг хүлэмжийн цахилгаан хангамж, гадна цэвэр усны ажил	2018	2018	50,000,000	50,000,000
1.2.3	Орон сууцны гадна фасад /10,11-р байр/	2018	2018	100,000,000	100,000,000
1.2.4	Шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамж	2018	2018	140,000,000	140,000,000
1.2.5	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх	2018	2018	150,000,000	150,000,000
1.2.6	Аймгийн төвийн ногоон байгууламжийн хайс хашаа	2018	2018	48,500,000	48,500,000
2. Тоног төхөөрөмж				229,607,900	229,607,900
2.1	Барилгын материалын чанарт хяналт тавих лабораторийн тоног төхөөрөмж	2018	2018	54,607,900	54,607,900
2.2	Эрдэнэдалай суманд хог зөөврийн автомашин	2018	2018	45,000,000	45,000,000
2.3	Аймгийн хэрэгцээнд эскаватор	2018	2018	130,000,000	130,000,000
3. Төсөл, хөтөлбөр арга хэмжээ				478,430,782	478,430,782
3.1	Аймгийн баяр наадам	2018	2018	10,000,000	10,000,000
3.2	Мал эмнэлгийн үйлчилгээ	2018	2018	236,016,000	236,016,000
3.3	Хот байгуулалт тохижилт	2018	2018	77,880,300	77,880,300
3.4	Бэлчээрийн жорлон мэрэгчтэй тэмцэх	2018	2018	36,334,482	36,334,482
3.5	Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх	2018	2018	40,000,000	40,000,000
3.6	Зураг төсөв	2018	2018	78,200,000	78,200,000
Орон нутгийн хөгжлийн сангийн нийт эх үүсвэр				1,362,697,500	1,362,697,500
1 2017 оны үлдэгдлээс санхүүжилт				-	-105,465,000
2 2018 онд санхүүжилт				-	1,257,232,500

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2017 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн тогтоолын хавсралт

БАТАВ, ДУНДГОВЬ АЙМГИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР БОГӨӨД, ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА /З. ЧАГНААДОРИ/

ДУНДГОВЬ АЙМАГ, САЙНЦАГААН СУМ, ГХБХБГазрын ОФИС, ЛАБОРАТОРИЙН БАРИЛГА /Ажлын зураг/

ЭЗЭМЖИЛЭЛЭЛ

Ажлын төрөл	Нэр	Ажлын төрөл	Нэр	Ажлын төрөл	Нэр
Ажлын төрөл	З. ЧАГНААДОРИ	Ажлын төрөл	З. ЧАГНААДОРИ	Ажлын төрөл	З. ЧАГНААДОРИ
Ажлын төрөл	З. ЧАГНААДОРИ	Ажлын төрөл	З. ЧАГНААДОРИ	Ажлын төрөл	З. ЧАГНААДОРИ

Улаанбаатар хот 2017

Лабораторийн барилгын ажлын зураг

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

Дүрэм батлах тухай

Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалт, Засгийн газрын 2014 оны 308 дугаар тогтоолын тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Барилгын материалын туршилт шинжилгээ, судалгааны ажил эрхлэх "Барилгын материалын лабораторийн дүрэм"-ийг хавсралтаар баталсуугай.

Хоёр. Барилгын материалын туршилт шинжилгээ, судалгааны ажил эрхлэх "Барилгын материалын лабораторийн дүрэм"-ийн хэрэгжилтийг хангах ажиллагааг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /З.Чаннаадогори/-г даалгасуугай.

Гурав. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг хангах талаар аймгийн Засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Н.Эрдэнэ-Очир/-г үүрэг болгосуугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2017 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн А/418 дугаар захирам

2018 онд төлөвлөж буй ажил: 2018 оны 2 дугаар улиралд барилгын материалын лабораторийн үйл ажиллагааг эхлүүлнэ.


3.4 ОРОН СУУЦ, НИЙТИЙН АЖ АХУЙ

3.4.1 ОРОН СУУЦ

2017 онд: Иргэдийг түрээсийн орон сууцанд үе шаттайгаар хамруулах зорилгоор түрээсийн орон сууцанд амьдрах сонирхолтой иргэдийн бодит судалгаанд аймгийн төвд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагуудын 1226 иргэн хамрагдсан байна. Судалгаанд хамрагдсан иргэдээс 53 өрх түрээсийн орон сууцанд амьдарч, 210 өрх түрээсийн сууцанд амьдрах сонирхолтой гэсэн байна.

32 айлын 3 орон сууцны барилга ашиглалтад орсон, баригдаж буй-18 айлын 2 орон сууцны барилга байна. Шинээр аштглалтад орсон болон баригдаж буй орон сууцны квадрат метрийн үнэ 1.1-1.2 сая төгрөг байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 5-8 хувиар өссөн байна.

Аймгийн хэмжээнд 903 айлын 64 нийтийн орон ашиглагдаж байгаагаас сүүлийн 7 жилд буюу 2012 оноос хойш 509 айлын 41 орон сууц ашиглалтад орсон нь орон сууцны 56,3% нь эзэлж байна. Зураг 3.4.1



Зураг 3.4.1. Ашиглалдаж буй орон сууцны ашиглалтад орсон хугацаа



Зураг 3.4.2. Сайнцагаан сум 7-р баг. 16 айлын орон сууцны барилга

3.4.2. НИЙТИЙН АЖ АХУЙ

2017 онд: Сайнцагаан сумын орон нутгийн хөгжлийн сангийн 25 сая төгрөгөөр 5 хогийн бункер худалдан авч нийт 12 хогийн бункертэй болсон. Аймгийн ОНХС-ийн 175,1 сая төгрөгөөр 2 орон сууцны гадна фасадыг засварласан. Мөн Мандалговь хотын ус хангамжийн эх үүсвэрт 38 сая төгрөгтийн үнэ бүхий 21 ширхэг хяналтын камер суурилууллаа.



Сайнцагаан сум. Иргэн Б.Бат-Өлзий халуун усны барилга



Халуун усны үйлчилгээнд шалгалт хийж байгаа нь



Сайнцагаан сум 7-р баг 9-р байр



Хог ачих авто машин, хогийн бункер



Хогийн цэгийн 4,2га талбайн 1000м3 хогийг



шууж, хөрсөөр тарсан

Зураг 3.4.1. Нийтийн аж ахуй үйлчилгээ

2018 онд төлөвлөж буй ажил: Орон нутгийн хөгжлийн сангийн 106 сая төгрөгөөр 5 бункер, 2 тусгай зориулалтын авто машин худалдан авч үйлчилгээнд нэмнэ.

5.1. СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА, ИЛ ТОД БАЙДАЛ

5.1.1 СУРГАЛТ

Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.6 дахь заалтын дагуу тус байгууллагын “Төрийн албаны сургалт ба мэдлэг чадварыг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн дагуу сургалтын төлөвлөгөөг жил бүр шинэчлэн баталгаажуулж хэвшсэн. Байгууллагын албан хаагчид ажлын байрандаа тасралтгүй суралцаж, сургалтанд хамрагдаж мэдлэг мэргэшлээ дээшлүүлэн ажиллаж байх нөхцлийг бүрдүүлсэн.

Байгууллагын албан хаагчдаас 2017 онд хамрагдах сургалтын саналыг авч сургалтын төлөвлөгөөнд тусгаж, төлөвлөгөөг байгууллагын даргаар баталгаажуулж, албан хаагчид төлөвлөгөөний дагуу сургалтанд хамрагдаж байна.

Жил бүр зохион байгуулдаг сумдын газрын даамлуудын сургалтыг 2017 оны 02 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулж, 2017 оны сумдын ЗДТГ-ын дарга болон даамлуудын гурвалсан үр дүнгийн гэрээг байгуулж хэрэгжилтийг тооцон ажиллалаа.



Дундговь аймгийн барилгын салбарын хөгжлийг цаашид тодорхойлох, төр болон барилгын салбарт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн хоорондын уялдаа холбоог сайжруулах, барилга барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжин ажиллахад чиглэгдсэн Дундговь аймгийн “БАРИЛГАЧДЫН ЗӨВЛӨГӨӨН– 2017” арга хэмжээг 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгууллаа. Тус зөвлөгөөнд Аймгийн Засаг дарга, Аймгийн ИТХ-ын дарга, ГЗБГЗЗГазар, БХТөв, Засаг даргын тамгын газрын ХОХБТХэлтэс, ГХБХБГ, МХГазар, ОБГазар, ОНӨГазар, Дундговь аймгийн барилгачдын холбоо, МСҮТ болон Барилга угсралтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжүүдийн төлөөлөл болох 60 гаруй хүн оролцсон.



Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн асуудлаар ГЗБГЗЗГ-ын ГЗБ-ын хэлтсийн мэргэжилтэн С.Энх-Эрдэнэ цахим системээр сургалтыг аймгийн ГХБХБГ-ын мэргэжилтнүүд болон сумын газрын даамлуудад зохион байгуулсан.



“Эн Эй Пи групп” ХХК-тай хамтран “Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны” сэдэвт сургалт зохион байгуулж, сургалтад холбогдох 23 хүн хамрагдсан.



“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах, дэд бүтцийн хүртээмжийг бий болгох тухай” Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд барилга байгууламж ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд орж ажиллах гишүүдийг чадавхжуулах сургалтыг аймгийн ХХҮГ-тай хамтран 2017 оны 10 дугаар сарын 27-ны өдөр зохион байгууллаа.



2017 оны 05 дугаар 12-15 өдрүүдэд БНХАУ-ын Манжуур хотноо зохион байгуулагдсан Зүүн бүсийн аймгуудын ГХБХБГ-ын албан хаагчдын зөвлөгөөнд оролцож туршлага солилцлоо.



Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Газар зохион байгуулалтын хэлтсийн дарга Ж.Батсайхан, мэргэжилтэн С.Дэнсмаа нар “Бэлчээрийн газрын зүй зохистой хэрэглээ”, “Хилийн цэс”-ийн талаар тус аймгийн сумдын Засаг дарга нар болон хэлтэс агентлагуудын дарга нарын 2017 оны 1-р сарын 17-18-ны өдрүүдэд мэдээлэл хийлээ.

Мөн тус байгууллагын Газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүдэд “Газар зохион байгуулалт”, “Бэлчээрийн газрын зүй зохистой хэрэглээ” сэдвээр сургалт зохион байгууллаа.



7 хоног бүрийн Пүрэв гаригт албан хаагчдыг ажлын байран дээрээ суралцаж, хууль эрх зүй болон хамрагдсан сургалтын талаарх мэдээллийг бусад албан хаагчидтай хуваалцах зорилгоор “Хуулийн цаг”-ийг зохион байгуулдаг. Тухайлбал:

- Мэдээллийн сан, техник, програм хангамж хариуцсан мэргэжилтэн Б.Солонго байгууллагын цахим удирдлагын систем /ABLE/-ийн тухай албан хаагчдад сургалт хийж албан хэрэг, албан бичиг, захидал, олон нийт програмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглах талаар



- Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга Д.Нэргүй Хот байгуулалтын тухай хууль сэдвээр албан хаагчдад сургалт хийлээ. Сургалтын дараа албан хаагчдаас дээрх сэдвээр тест авч, асуулт хариултын талаар ярилцлаа.



- Замын хөдөлгөөний дүрэм, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, 2016 оны гэмт хэргийн талаарх мэдээлэл, албан хаагчдын сахилга хариуцлагын талаар болон Гэр бүлийн хүчирхийлэл сэдвээр сургалт зохион байгуулсан.



2017 оны 03 дугаар сарын 11-ний өдөр Монголын Газар зохион байгуулалтын Дундговь аймаг дахь салбар холбоог байгуулж төв холбооноос газар зүйн мэдээллийн системийн ArcGIS 10.1 програмын сургалтыг тус байгууллагын Газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүдэд 2017 оны 03 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд зохион байгуулсан.



5.1.2 ДОТООД ХЯНАЛТ, ИЛ ТОД БАЙДАЛ

Байгууллагын даргын 2016 оны 11 дүгээр сарын 09-ний А/48 дугаар тушаалаар батлагдсан дотоод хяналт шалгалтын нэгж байгуулах журмын дагуу мэргэжилтэнүүдийн үйл ажиллагаа, үр дүнгийн гэрээнд дотоод хяналт шалгалтыг хийж ажиллалаа. Мөн сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт болон газрын даамлын үйл ажиллагаанд хяналт шинжилгээг хийх ажлын удирдамж, төлөвлөгөөг байгууллагын даргаар батлуулсан хуваарийн дагуу 2017 оны 09 сарын 08-30-ний өдрүүдэд Луус, Эрдэнэдалай, Сайнцагаан, Сайхан-Овоо, Адаацаг сумдын тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт шинжилгээ хийж тайланг 2017 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 1/422 тоот албан бичгээр ГЗБГЗЗГ-т хүргүүллээ. Цаашид анхаарч ажиллах ажлын талаар сумдын удирдлагууд болон газрын даамалд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. 2018 онд үлдсэн 10 суманд хяналт шалгалтыг хийхээр төлөвлөн ажиллаж байна.

Төрийн үйл ажиллагааны чанар хүртээмжийг дээшлүүлэх, газрын харилцааны үйл ажиллагааг иргэдэд ил тод, нээлттэйгээр сурталчлах, таниулах зорилгоор “Иргэн таныг сонсож байна” арга хэмжээг Луус, Эрдэнэдалай, Адаацаг, Сайхан-Овоо, Гурвансайхан, Өндөршил, Хулд, Луус сумдад зохион байгуулж

давхардсан тоогоор 1327 иргэнд газар дээр нь газрын харилцаатай холбоотой үйл ажиллагааг үзүүлж ажиллалаа.




Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гарын авлага

Дундговь аймгийн Зэвсэгт хүчний 278-р ангийн ажилчид албан хаагчдад газрын тухай хууль, газар өмчлөх, эзэмших үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл хийж анхан шатны үйлчилгээг үзүүлсэн. Дээрх арга хэмжээнд 51 албан хаагчид хамрагдаж МУ-ын иргэнд Газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу 55 иргэнээс шинээр газар өмчлөх өргөдөл хүлээн авч газар өмчлөх захирамж гарсан 13 иргэнд газрын хянан баталгаа кадастрын зургаар үйлчилгээ үзүүлж ажиллалаа.



Байгууллагын цахим хуудас **dundgovi.gazar.gov.mn** болон орон нутгийн цахим хуудас **dundgovi.gov.mn**, байгууллагын facebook хуудсанд орон нутаг дахь салбарын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг тогтмол оруулан мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг ханган ажиллаж байна. 2017 он гарсаар дээрх цахим хуудаснуудад нийт 70 гаруй мэдээ мэдээллийг оруулж тогтмол баяжуулалт хийн ажилласан бөгөөд байгууллагын цахим хуудсанд нийт 800 гаруй иргэд хандалт хийж мэдээ мэдээллийг авсан байна.



Барилга, хот байгуулалтын яамны Дэд сайд Ш.Лхамсүрэн 2017 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр Дундговь аймгийн Мандалговь хотод ажилласан бөгөөд Мандалговь хотод шинээр баригдахаар төлөвлөж буй хоногт 4200м3 бохир ус цэвэршүүлэх байгууламж, одоо ашиглагдаж буй механик ажиллагаатай цэвэрлэх байгууламжийн өнөөгийн байдал мөн хоногт 35МВт хүчин чадалтай Дулааны цахилгаан станцын газар дээр очиж нөхцөл байдалтай мөн Өлзийт сумын “Сумын төвийн шинэчлэлт төсөл”-ийн хүрээнд хийгдсэн ажилтай газар нь очиж танилцаж MNB-ийн 2 дугаар суваг болон орон нутгийн Ард, Цоглог телевизээр иргэд олон нийтэд сурталчилж ажилласан.



Барилгын хөгжлийн төвийн 2017 оны 10 дугаар сарын №05/360/ дугаартай “Барилгын мэдээлэл” сэтгүүлд Дундговь аймгийн Өлзийт суманд “Сумын төвийн шинэчлэл” төсөл амжилттай хэрэгжлээ гарчигтай мэдээ мэдээлэл хэвлүүлж ажиллалаа.

